



Байнгын хорооны 2022 оны 15
дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Нэргүй Ургийн овог: Бат-Нэр Нэр: Мягмар Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1976 Төрсөн газар: Булган аймгийн Дашинчилэн сум Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.

	<p>1.American University, Washington College of Law, хууль зүйн ухааны магистр- LL.M (2005)</p> <p>2.МУИС-Хууль зүйн дээд сургууль, хууль зүйн магистр зэрэг (1999)</p> <p>3.МУИС-Хууль зүйн дээд сургууль, эрх зүйч мэргэжил, бакалавр (1994-1998)</p>
1.5	<p>Эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>-2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс ЗГХЭГ-ын дэд дарга</p> <p>-2024-2026 онд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга</p> <p>-2023-2024 онд УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга</p> <p>-2018-2023 онд ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга</p> <p>-2017-2018 онд Азийн хөгжлийн банкны төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн менежер</p> <p>-2014-2016 онд МУ-аас АНУ-ын Сан Франциско хотод суугаа Ерөнхий консулын газарт Консул</p> <p>-2012-2014 онд Хууль зүйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга</p> <p>-2010-2012 онд Монголын хөлөг онгоцны бүртгэл ХХК-ийн Захиргааны менежер</p> <p>-2009-2010 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал</p> <p>-2007-2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга</p> <p>-2006-2007 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар болон Төрийн захиргааны удирдлагын газарт ахлах мэргэжилтэн</p> <p>-1999-2006 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд багш</p>
1.6	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.7	<p>Эрүүгийн хариуцлага</p> <p>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/</p> <p>Үгүй</p>
1.8	Яллагдагчаар татагдсан эсэх

	<p>Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/.</p> <p>Үгүй</p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар</p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>-Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>-Монголын хуульчдын холбооны гишүүн</p> <p>-Улаанбаатар хот дахь Дашинчилэн сумын нутгийн зөвлөлийн тэргүүлэгч</p>
1.11	<p>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p> <p>Эрдэм шинжилгээний 5 өгүүлэл хэвлүүлж, “Төрийн албанд захиргааны албан хаагчийг шилж сонгох зарим асуудал” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Магистрын ажил- 1999 он “Монгол Улсын Төрийн албанд захиргааны албан хаагчийг шилж сонгох зарим асуудал” 2. Эрдэм шинжилгээний өгүүлэл:

	<ul style="list-style-type: none"> - “Төрийн зохицуулалтын тухай гүн ухааны зарим хандлага”, “Эрх зүй” сэтгүүл №1, 2000 он - “Шүүхийг өөрөөр ойлгохуй”, “Эрх зүй” сэтгүүл №2-3, 2000 он - “Төрийн захиргааны албан хаагчийг шилж сонгох асуудалд”, “Эрх зүй” сэтгүүл №4-5, 2001 он - “Хот, тосгоны захирагч ба Засаг даргын эрх зүйн байдал: ялгаа, онцлогийн тухайд”, “Эрх зүй” сэтгүүл №6-7, 2001 он - “Гүйцэтгэх засаг ба эрх мэдлийн тухайд”, “Эрх зүй” сэтгүүл №8-9, 2002 онд тус тус нийтлүүлэн хэвлүүлсний зэрэгцээ 2001 онд Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас Шинжлэх ухааны болон практикийн ажилтнуудын дунд зарласан Захиргааны хэргийн шүүхийг нийтэд танилцуулах эрдэм шинжилгээний нийтлэлийн улсын уралдаанд дэд байр эзэлж байсан.
	<p>3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргаар ажиллаж байхдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж, УИХ-аар батлуулсан. Түүнчлэн, дараах хууль тогтоомжийг боловсруулах ажлыг хариуцсан референт, ажлын хэсгийн хамт зохион байгуулж, УИХ-д өргөн мэдүүлсэн болон батлуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай • Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Радио долгионы тухай • Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай" конвенцыг соёрхон батлах тухай • Дэлхийн шуудан холбооны байгууллагын дүрэм, конвенцод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай • Терроризмтой тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ • Зөвшөөрлийн тухай • Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай <p>Монгол Улсын Их Хурал Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Засгийн газраас боловсруулан батлах дараах журмуудыг мөн хариуцсан референт, ажлын хэсгийн хамт боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам • Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр • Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам

	<ul style="list-style-type: none"> • Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ • Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам • Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам • Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх <p>Улсын Их Хурлын 2020 оны 5 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулсан ажлын хэсэгт “Үндэсний аюулгүй байдал” ажлын дэд хэсгийн даргаар үр бүтээлтэй ажиллаж, удирдлага, зохион байгуулалтыг хангаж ажилласан.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллах хугацаанд тус яамнаас хариуцан боловсруулах хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн дийлэнхийг ахалж ажилласан болно.</p>
--	---

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p>
	<p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР ТОМИЛОГДСОН ТОХИОЛДОЛД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д " Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ." гэж, мөн Арван зургадугаар зүйлийн 9-д зааснаар иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй болохыг тус тус баталгаажуулсан байдаг. Энэхүү үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд Сонгуулийн ерөнхий хороо онцгой үүрэгтэй бөгөөд сонгуулийн үйл ажиллагааны шударга, ил тод, хараат бус байдлыг хангах нь тус байгууллагын эрхэм зорилго мөн.</p> <p>Хэрэв Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол өнөөдрийг хүртэл бий болсон сонгуулийн тогтолцооны ололт амжилтыг хадгалан хөгжүүлж, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагад олон жил ажилласан туршлага, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад</p>

ажилласан мэдлэг чадвараа ашиглан сонгуулийн тогтолцооны хөгжил, шинэчлэлд хувь нэмэр оруулахыг зорино.

Миний бие Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн асуудал хариуцсан удирдах албан тушаалд ажиллаж байхдаа хууль тогтоомж боловсруулах, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр ажилласан. Энэхүү туршлага нь сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, институцийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн багш, судлаачаар ажилласан туршлагадаа тулгуурлан судалгаанд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, сонгуулийн үйл ажиллагааны талаарх судалгаа, шинжилгээг өргөжүүлэх, бодлого боловсруулах үйл явцад эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

Дэлхий нийтэд сонгуулийн удирдлагын байгууллагууд дижитал шилжилт, мэдээллийн аюулгүй байдал, нээлттэй засаглалын чиглэлээр эрчимтэй хөгжиж байна. Иймд сонгуулийн автоматжуулсан системийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, сонгогчдын бүртгэл, санал тоолох төхөөрөмж, мэдээлэл дамжуулах болон хадгалах системийн аюулгүй байдлыг олон улсын стандартад нийцүүлэн тогтмол аудит, хөндлөнгийн үнэлгээнд хамруулах, кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор системийн ажиллагааны талаарх мэдээллийг ил тод хүргэх шаардлагатай гэж үздэг.

Сонгуулийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх асуудал мөн чухал юм. Сонгуулийн төв байгууллага болон орон нутгийн сонгууль зохион байгуулахад оролдог ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хууль хэрэглээний мэдлэг, мэдээллийн технологийн чадавх, ёс зүйн стандартыг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Сонгуулийн байгууллага нь мэргэжлийн, тогтвортой, улс төрөөс ангид төрийн албаны зарчимд тулгуурлан хөгжих ёстой гэж үздэг.

Мөн төсвийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна. Сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулагдаж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай, ил тод зарцуулах, төсвийн төлөвлөлтийг хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц, эрсдэл болон хэрэгцээнд суурилан төлөвлөж батлуулах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагууд, тухайлбал, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газар (ODIHR), Сонгуулийн тогтолцооны олон улсын хүрээлэн (International IDEA) зэрэг байгууллагууд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, тайлагнал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгохыг зөвлөмж болгосоор ирсэн. Иймд холбогдох хуульд

	<p>заасан нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, хандивын эх үүсвэр, санхүүжилтийн мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр нээлттэй мэдээлэх, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, дүн шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь сонгуулийн шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэдийн итгэлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.</p> <p>Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх нь ардчиллын чанарыг сайжруулах үндсэн нөхцөл мөн. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, International IDEA болон бусад байгууллагууд сонгогчдын боловсролыг сонгуулийн үеэр бус тасралтгүй хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Энэхүү зөвлөмжийн дагуу боловсролын байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэдийн сонгуулийн боловсролыг насан туршийн суралцахуйн зарчимд тулгуурлан хөгжүүлэхийг дэмжинэ.</p> <p>Ялангуяа залуу сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх нь Монгол Улсын ардчиллын ирээдүйтэй шууд холбоотой асуудал юм. Анх удаа санал өгөх иргэдэд зориулсан сургалт, мэдээллийн хөтөлбөр хэрэгжүүлэх, их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулиудын иргэний боловсролын агуулгыг дэмжих, нийгмийн сүлжээ болон дижитал платформ ашиглан залуучуудад чиглэсэн сонгогчдын боловсролын шинэ хэлбэрүүдийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, алслагдсан бүс нутгийн сонгогчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хүртээмжтэй бодлогыг хэрэгжүүлэх нь сонгуулийн байгууллагын нэн тэргүүний зорилтын нэг байх ёстой. Сонгуулийн үйл ажиллагаанд хүн бүр тэгш оролцох боломжийг бүрдүүлэх нь Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх бодит баталгаа болно.</p> <p>Эцэст нь Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол хараат бус байдал, хууль дээдлэх зарчим, ил тод байдал, хариуцлагыг үйл ажиллагааныхаа үнэт зүйл болгон баримталж, иргэдийн сонгох эрхийг бүрэн хангах, сонгуулийн байгууллагын нэр хүнд, олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын ардчиллын хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө мэдлэг, туршлагаа зориулан ажиллах болно.</p>
--	--

Хавсралт:

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- иргэний үнэмлэхийн хуулбар;

- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

- боловсролын зэргийн дипломын хуулбар;

- хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;

- тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;

- энэхүү загварт заасан баримт бичиг;

- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: НЭРГҮЙ

Өөрийн нэр: МЯГМАР

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026-06-09.